



МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

СОЙМБОМ ЭДЭЭ

№238 /447/ 2022.01.03

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

Цаг үе, үйл явдал

ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЖ, ХАРИУЦЛАГАА ДЭЭШЛҮҮЛЭН АЖИЛЛАХЫГ УРИАЛАВ

Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-өөс Зэвсэгт хүчний 326, 120, 119 дүгээр ангиудын офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын ёс суртахуун, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгууллаа.

Тухайлбал, Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор, Отгонтэнгэр их сургуулийн багш, Иргэний зөвлөлийн гишүүн Б.Галиндэв "Ёс суртахуун", "Эх оронч үзэл, бахархал" "Албаны харилцаа хандлага", Монгол Улсын Төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, анагаах ухааны доктор, профессор, Цэргийн төв эмнэлгийн зөвлөх эмч, Иргэний зөвлөлийн гишүүн Л.Жамбалжав "Эрүүл байхын үндэс", "Залуучуудын эрүүл мэндийн боловсрол" сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлгийг зохион байгуулж алба хаагчдад



мэдлэг олгосон юм.

Сургалтын төсгөлд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албаны мэргэжилтэн, "Иргэний

зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга хошууч А.Октябрь Батлан хамгаалахын хяналт шалгалтын нэгжүүдээс 2022 онд цахим нөлөөллийн аяны хүрээнд хэрэгжүүлсэн

"Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа", "Ёс зүй, сахилга хариуцлагын үндэс", "Зохистой амралт Аюулгүй хөдөлгөөн", "Зөв харилцаа Зөв хандлага" сэдэвт санамж, уриалгуудыг танилцуулж, ажил албандаа мөрдлөг болгож, хариуцлагаа дээшлүүлэн ажиллахыг нийт бие бүрэлдэхүүнд уриаллаа.

Тус сургалт нь бие бүрэлдэхүүний сэтгэл зүй болон нийгмийн асуудлыг таньж мэдэх, шийдвэрлэх гарц гаргалгааг зааж өгсөн, үр өгөөж сайтай байсныг алба хаагчид онцолсон бөгөөд дараачийн удаа давтан сургалт зохион байгуулахыг "Иргэний зөвлөл"-ийн гишүүдэд уламжилсан байна.



ШАГНАЛЫН ХҮР БУУСААР



Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын ахмадууд болон ажилтан албан хаагчид Монгол Улсын одон медаль болон салбарын шагналуудаар энгэрээ мялаалаа.

Тухайлбал "Цэргийн гавьяаны улаан тугийн одон"-оор бэлтгэл ахлах ахлагч бүжигчин Ж.Норовсүрэн, "Цэргийн хүндэт медаль"-аар бэлтгэл ахлах ахлагч дуучин Д.Жаргалсайхан, "Хөдөлмөрийн хүндэт медаль"-аар ЦДБЭЧ-ын хөгжимчин МУСТА Г.Гантөмөр, Б.Бямбадорж, ХНХЯ-ны "Тэргүүний ажилтан цол тэмдэг"-ээр Д.Цэцэг, Д.Энхбаяр, БХЯ-ны "Жуух бичиг"-ээр Г.Болдбаяр, Б.Тунгалаг, О.Ган-Эрдэнэ, "Банк Санхүүгийн Тэргүүний ажилтан цол тэмдэг"-ээр А.Энхзаяа, Г.Уранбилэг нар тус тус шагнуулж энгэрээ мялаалгасан юм.



"GRAND AWARDS 2022" НААДМААС "ШИЛДЭГ ЧУУЛГА" ШАГНАЛЫГ ХҮРТЛЭЭ



Монголын Маркетинг Менежментийн хүрээлэнгээс уламжлал болгон зохион байгуулдаг "GRAND AWARDS" наадмаас 2022 оны оны шоу энтертаймент салбарын "Шилдэг чуулга"-аар Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгыг нэрлэжээ.

Тус хүрээлэн нь жил бүр салбар салбартаа амжилт гаргаж, шинэ санаа, шинэлэг инновацыг нэвтрүүлэн олон жил тогтвортой үйл ажиллагаа явуулж, Монгол Улсын эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулж буй аж ахуй нэгжүүдийг онцлон шагнал гардуулдаг билээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-18	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.465	3.475
EUR	3.710	3.730
CNY	500	504
RUB	46.50	47.80
JPY	26.30	26.55
KRW	2.73	2.75

ЗУРХАЙ



ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

Наран ургах, шингэх:

08.42-17.11

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

САНСАР

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, бурханы ёс ба тарни бүтээх, амраг нөхдийг хураахуйд сайн. Баруун чих хангинавал асрагдах, зүүн нь бол буян арвижих, нохой уливал гэрийн тэнгэр зайлсан, хэрээ гуаглалал эд агуурс олдох, тагнай загатнавал зочин ирэх, бие татвал гаслан болох, хөл татвал хувцас олдоно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 665,619,701

Эдгэрсэн

Нийт: 637,713,282

Нас барсан

Нийт: 6,699,470

Цахим шууданд

ХОВДЫН ДОМОГТ ХОРООНЫХОН ОНЫ ШИЛДГҮҮДЭЭ ОНЦЛОВ



Зэвсэгт хүчний 123 дугаар анги 2022 оны үйл ажиллагааны тайлангаа дүгнэж, цэргийн алба, сахилга хариуцлага, сургалт бэлтгэл, ажлын амжилтаараа бусдыгаа тэргүүлсэн алба хаагчдаа шагнаж урамшуулав.

Тус ангийн "Тэргүүний алба"-аар инженерийн алба, "Тэргүүний офицер"-оор артиллерийн дарга хошууч Н.Баярсайхан, "Тэргүүний ахлагч"-аар артиллерийн батареины ахлагч Ж.Түмэн-Орших, "Тэргүүний ажилтан алба хаагч"-аар мөнгөн хөрөнгө, үнэт цаасны нярав Б.Энхтуяа, "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар морьт сумангийн байлдагч О.Ууганбаатар, "Тэргүүний хугацаат цэргийн алба хаагч"-аар мотобуудлагын ротын байлдагч Ш.Билэгт нар тус тус шалгарлаа.

Дэд ахлагч Б.УЯНГА



ЦЭРГИЙН ДУУ БҮЖГИЙН ЭРДМИЙН ЧУУЛГЫН 2022 ОНЫ МАНЛАЙЛАГЧИД...



-Манлайлагч хамт олон "БҮЖГИЙН АЛБА"
 -Бүтээлч хамт олон - "ҮНДЭСНИЙ НАЙРАЛ ХӨГЖИМ"
 -Бүтээлч хамт олон - "САНХҮҮГИЙН АЛБА"
 -Бүтээлч хамт олон - "АЖ АХУЙН АЛБА"
 -Шилдэг уран бүтээл - "ҮНЭ ЦЭН" мюзикл
 -Шилдэг тоглолт - "СОНГОДОГ ЭГШИГЛЭН"
 -Шилдэг уран бүтээлчид - "ГОЦЛОЛ ДУУЧИД"
 (МУГЖ Б.Батбаатар, МУСТА Н.Батсайхан, МУСТА Д.Даваадорж, МУСТА Р.Амартер, МУСТА Т.Жавхланням)
 -2022 оны "Шилдэг офицер" - Уран бүтээлийн хэлтсийн дарга-Ерөнхий найруулагч, дэд хурандаа Б.Энхбаяр
 -2022 оны "Шилдэг ажилтан" - Урын сангийн эрхлэгч Б.Мөнхцэцэг



ҮНЭН ХҮЧИЙГ ҮЗЭН БАРИЛДАВ



Батлан хамгаалах яамны харьяа "Алдар" спорт хорооноос "Алдарын цом" үндэсний бөхийн шилжин явах цомын аварга шалгаруулах барилдааныг зохион байгууллаа. Тэмцээнд Аймгийн начин цолтой 39-н бөх оролцож тойргийн журмаар барилдахад тэргүүн байрт Алдар спорт хороо, Ховд аймаг, Мөст сум аймгийн начин дэд ахлагч М.Баяржавхлан, Дэд байрт Төв аймгийн Бүрэн сум Дүнжингарав дэвжээ аймгийн начин Л.Энхтүвшин, Гутгаар

байрт Архангай аймаг, Хайрхан сум Бөх билэгт дэвжээ аймгийн начин О.Баярбаасан, дөрөвдүгээр байрт Хөвсгөл, Цагаан-Уул сум, Хөвсгөлийн хүчтэн дэвжээ аймгийн начин Г.Бат-Эрдэнэ, Тавдугаар байрт Хилчин спорт хороо Завхан аймаг Баянтэс сум аймгийн начин Х.Болдбаатар, Зургаадугаар байрт Хэнтий аймаг, Жаргалтаан сум, Хан хэнтий аварга дэвжээ аймгийн начин Т.Дэчинжүрмид нар шалгарлаа.

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №49

СА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ
 СА бол дэвсгэр үсэг, хатуу дэвсгэрийн нэг юм. Тиймээс үгийн дунд, адагт ардаа эгшиггүй тохиолдож болно. Бүтэц зурлагын хувьд "завьж"-т үсэг болой. Завьж зурлагыг үзгээ салгалгүй бичиж төгсгөнө. Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог СА, СЭ, СИ, СО, СУ, СӨ, СҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогоорой. Харин СИ үеийг ШИ гэж дууддаг. Монгол хэлнээ СИ гэсэн үе байдаггүй билээ.

Бичмэл тигээр:

